



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025. 06. 19 № ЗГ-1/76
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тухай

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР

000254000298



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,

Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.05.23 № ХЭГ/1481

танай _____-ны № _____-т


**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлдох тухай**

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлж өгөхийг хүсье.

Хавсралт 37 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ


000255000506

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 24 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“30.ХЭЛЭЛЦСЭН нь: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025.05.22 № 01/4648

танай 2025.05.21-ны № 01/1531 -т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД Ж.ЭНХБАЯР ТАНАА

Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000973



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.05.21 № 42786

танай _____-ны № _____-т

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
Ж.ЭНХБАЯР ТАНАА**

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19^{1.1} дэх хэсэгт заасан Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.



О.АЛТАНГЭРЭЛ

151802419

A5.файл.2025



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.05.22 № 1/2796

танай _____-ны № _____-т

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
Ж.ЭНХБАЯР ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ

151603400

A5.файл.2025



**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.10-т “хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг” гэж заасан бөгөөд мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах нь хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гол үйл ажиллагаа юм.

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн тогтворжуулах татварын орчныг Хөрөнгө оруулалтын тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу тогтоох, чөлөөт бүсэд мөрдөгдөх татварын тусгай дэглэмийг Чөлөөт бүсийн тухай хуулиар тогтоож, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг татварын холбогдох хуулиар зохицуулахаас бусад тохиолдолд татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй” гэж заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.2.1-д “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 3.4.2.3-т “Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана.” гэж тус тус заасан.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Засгийн газраас мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай даван туулах, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний

хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор гурил, гурилан бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, нөөцийг харгалзан жилийн нийт хэрэгцээний 10 хүртэл хувь буюу 25.0 мян.тн улаанбуудайн гурилыг Монгол Улсын хилийн боомт бүхий аймгуудаар, гаалийн албан татваргүйгээр 2024 оны 07 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд импортлохоор тооцоо судалгааг хийж, “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл” боловсруулан Улсын Их Хуралд өргөн барьсан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль”-ийг хэлэлцэн, улаанбуудайн гурил, мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлж, тоо хэмжээний болон хугацааны хязгаарлалтгүй импортлохоор эцэслэн баталсан.

Энэ хуулийн хүрээнд Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Жагсаалт батлах тухай” 180 дугаар тогтоолын хавсралтаар “Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, улаанбуудайн гурилын жагсаалт”-ыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн ангиллын дагуу баталсан.

Эдгээр бүтээгдэхүүний импортын гаалийн албан татварыг чөлөөлсөнтэй холбоотой хилийн боомтуудаар орж ирэх гурилын хэмжээ эрс нэмэгдэж, 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 64.2 мян.тн улаанбуудайн гурил, 65.2 мян.тн мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, 2025 оны 04 сарын гүйцэтгэлээр 18.1 мян.тн улаанбуудайн гурил тус тус импортолсон нь анх тооцоолсноос дариу 2-3 дахин их гүйцэтгэлтэй байна.

2024 онд импортолсон улаанбуудайн гурилын тоо хэмжээг хилийн боомт тус бүрээр авч үзвэл, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомтоор 35.9 мян.тн, Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтоор 14.1 мян.тн, Увс аймгийн Боршоо боомтоор 10.3 мян.тн хэмжээгээр Оросын Холбооны Улсаас тус тус импортолсон бөгөөд үүнээс 40.4 мян.тн нь улаанбуудайн дээд гурил, 23.8 мян.тн нь улаанбуудайн I зэргийн гурил байсан байна.

Хуулийг мөрдөж эхлэх үед буюу 2024 оны 04 дүгээр сарын статистик мэдээгээр улаанбуудайн I зэргийн 1 кг гурилын үйлдвэрийн дундаж үнэ 1802 төгрөг байсан бол 2025 оны 04 дүгээр сарын байдлаар 1745 төгрөг буюу дотоодын үйлдвэрийн гурилын үнэ харьцангуй тогтвортой байна.

Монгол Улсын жишсэн хүн амын тоо 2024* онд 2.799.2 мянга гэж тооцвол 106.3 мян.тн гурил, 191.3 мян.тн гурилан бүтээгдэхүүн хэрэгцээтэй бөгөөд нийт хүн амын хэрэгцээнд 240.0 мян.тн гурил буюу 320.0 мян.тн улаанбуудай шаардлагатай байна.

Улсын хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулж буй 9 үйлдвэр шинэ ургацаас 160 мянган тн улаанбуудай хүлээн авсан ба 2025 оны 05 дугаар сарын 16-ны байдлаар гурилын үйлдвэрүүдийн агуулахад 118.3 мянган тн улаанбуудай, 26.8 мянган тн гурил, 7.5 мянган тн хивэгийн нөөцтэй байна.

Үүнээс үзвэл, тухайн цаг үеийн хүндрэлтэй нөхцөл байдалд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байдлыг хангах, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг

тасалдуулахгүй байх зорилгоор улаанбуудайн гурил болон мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон гаалийн албан татвараас чөлөөлөхөөр баталсан хууль зорилгодоо хүрсэн байна.

Хэдийгээр хуулийн хэрэгжилт хангагдаж, гурилын нийлүүлэлт нэмэгдэж, үнэ тогтвортой байгаа боловч дотоодын үр тариа, гурил үйлдвэрлэлийн сүлжээнд сөрөг нөлөө учруулсаар байна.

Өөрөөр хэлбэл, энэ хуулийн үйлчлэл зөвхөн улаанбуудайн гурил үйлдвэрлэгчийн үйл ажиллагаанд нөлөөлөх бус хөдөө аж ахуйн салбарын суурь үйлдвэрлэл болох газар тариалангийн үйлдвэрлэлд үлэмж хохирол учруулахаас гадна мал аж ахуйн болон тэжээлийн үйлдвэрлэл, тариалангийн техник тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, бордооны ханган нийлүүлэлтийн үйл ажиллагаанд шууд нөлөөлж байна.

Түүнчлэн, манай улсын газар тариалан, мал аж ахуй, хүнсний салбарын үйл ажиллагаа биднээс үл хамааран уур амьсгалын өөрчлөлтийн болон олон улсын ээдрээт харилцаа, эдийн засгийн таагүй нөлөөнд мэдрэг байсаар байгаа бөгөөд цаашид таамаглах боломжгүй нөхцөл байдал үүсэхийг үгүйсгэх аргагүй юм. КОВИД цар тахлын сорилтууд бидэнд бие даасан, тогтвортой, тэсвэртэй, даван туулах хүч чадалтай байх сургамжийг өгсөн нь саяхан билээ.

Цаашид энэхүү хуулийн үйлчлэл хугацаагүйгээр үргэлжлэх нь хөдөө аж ахуйн салбарыг уналтад оруулж, стратегийн хүнсний үйлдвэрлэл, хангамжийн тогтолцоог гажуудуулж, улмаар Монгол Улсын хүнсний баталгаат, аюулгүй байдлын эрсдэлт, эмзэг нөхцөл байдлыг нэмэгдүүлж байна.

Мөн гурилын импортын албан татварыг үргэлжлүүлэн чөлөөлөх нь Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилж, Улсын Их Хурлаар баталсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын “Атрын IV тариалангийн тогтвортой хөгжлийн аян” зэрэг дунд хугацааны бодлоготой уялдаагүй бөгөөд эдгээрийн хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнд сөргөөр нөлөөлж, аж ахуйн нэгж, үйлдвэрлэгч, малчид, тариаланчдийг өрийн дарамтад оруулах, хөдөөд ажлын байрыг бууруулах, хот, сууринд шилжин ирэгсдийн тоо, нягтралыг нэмэгдүүлэхэд түлхэц болохоор байна.

Хүнсний тухай хуулиар монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг “стратегийн хүнс” гэж тодорхойлон эдгээр хүнсний дотоодын үйлдвэрлэл, хангамжийг тогтвортой байлгах, улирлын нөөц бүрдүүлэх, гамшгийн нөөц бүрдүүлэх, импортын хамаарлыг бууруулахад чиглэсэн бодлогын болон санхүүжилтийн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Өөрөөр хэлбэл, монгол хүний анхдагч, суурь хүнсний хэрэглээ нь “стратегийн хүнс” бөгөөд эдгээрийг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах чадавхитай байх нь манай улсын хүнсний аюулгүй байдлын баталгаа төдийгүй, Үндэсний аюулгүй байдлын нэгэн чухал илэрхийлэл гэж үзэж болно.

Нэмж хэлбэл, импортын хараат байдлаас ангижрах бодлогыг цаг ямагт ахиулах нь Үндэсний эрх ашгийг хангах тусгаар улсын үүрэг билээ.

Иймээс, хөдөө аж ахуйн салбарт үүссэн бодит нөхцөл байдлыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль”-ийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд дахин өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг хоёр зүйлтэй байхаар боловсруулна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсон тухай, 2 дугаар зүйлд хуулийн дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар, гарах үр дүн

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар гарна:

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хэвийн үйл ажиллагааг хангана.

Хүн амын стратегийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах нөхцөл бүрдэнэ.

Стратегийн хүнсний хангамжийн тогтвортой байдал, сөрөн тэсвэрлэх чадавхи бэхжинэ.

Хөдөөд ажлын байрыг хадгалж, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна.

Газар тариалан, мал аж ахуй, гурил үйлдвэрлэлийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

Үндэсний эрх ашиг хангагдана.

Дөрөв.Хууль гарсантай холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд төсөл батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах хууль байхгүй.

-----oOo-----

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.2.1-д “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 3.4.2.3-т “Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана.” гэж тус тус заасныг хэрэгжүүлэхээр Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг хоёр зүйлтэй байхаар боловсруулсан ба хуулийн төслийн 1 дүгээр зүйлд 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсон тухай, 2 дугаар зүйлд хуулийн дагаж мөрдөх хугацааг тус тус тусгасан болно.

Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагын талаар: Монгол Улсын Засгийн газраас мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай даван туулах, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор гурил, гурилан бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, нөөцийг харгалзан жилийн нийт хэрэгцээний 10 хүртэл хувь буюу 25.0 мян.тн улаанбуудайн гурилыг Монгол Улсын хилийн боомт бүхий аймгуудаар, гаалийн албан татваргүйгээр 2024 оны 07 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд импортлохоор тооцоо судалгааг хийж, “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл” боловсруулан Улсын Их Хуралд өргөн барьсан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль”-ийг хэлэлцэн, улаанбуудайн гурил, мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлж, тоо хэмжээний болон хугацааны хязгаарлалтгүй импортлохоор эцэслэн баталсан.

Энэ хуулийн хүрээнд Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Жагсаалт батлах тухай” 180 дугаар тогтоолын хавсралтаар “Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, улаанбуудайн гурилын жагсаалт”-ыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн ангиллын дагуу баталсан.

Эдгээр бүтээгдэхүүний импортын гаалийн албан татварыг чөлөөлсөнтэй холбоотой хилийн боомтуудаар орж ирэх гурилын хэмжээ эрс нэмэгдэж, 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 64.2 мянган тонн улаанбуудайн гурил, 65.2 мянган тонн мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, 2025 оны 04 сарын гүйцэтгэлээр 18.1 мянган тонн улаанбуудайн гурил тус тус импортолсон нь анх тооцоолсноос дариу 2-3 дахин их гүйцэтгэлтэй байна.

2024 онд импортолсон улаанбуудайн гурилын тоо хэмжээг хилийн боомт тус бүрээр авч үзвэл, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомтоор 35.9 мянган тонн, Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтоор 14.1 мянган тонн, Увс аймгийн Боршоо боомтоор 10.3 мянган тонн хэмжээгээр Оросын Холбооны Улсаас тус тус импортолсон бөгөөд үүнээс 40.4 мянган тонн нь улаанбуудайн дээд гурил, 23.8 мянган тонн нь улаанбуудайн I зэргийн гурил байсан байна.

Хуулийг мөрдөж эхлэх үед буюу 2024 оны 04 дүгээр сарын статистик мэдээгээр улаанбуудайн I зэргийн 1 кг гурилын үйлдвэрийн дундаж үнэ 1802 төгрөг байсан бол 2025 оны 04 дүгээр сарын байдлаар 1745 төгрөг буюу дотоодын үйлдвэрийн гурилын үнэ харьцангуй тогтвортой байна.

Монгол Улсын жишсэн хүн амын тоо 2024* онд 2.799.2 мянга гэж тооцвол 106.3 мянган тонн гурил, 191.3 мянган тонн гурилан бүтээгдэхүүн хэрэгцээтэй бөгөөд нийт хүн амын хэрэгцээнд 240.0 мянган тонн гурил буюу 320.0 мянган тонн улаанбуудай шаардлагатай байна.

Улсын хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулж буй 9 үйлдвэр шинэ ургацаас 160 мянган тонн улаанбуудай хүлээн авсан ба 2025 оны 05 дугаар сарын 16-ны байдлаар гурилын үйлдвэрүүдийн агуулахад 118.3 мянган тонн улаанбуудай, 26.8 мянган тонн гурил, 7.5 мянган тонн хивэгний нөөцтэй байна.

Үүнээс үзвэл, тухайн цаг үеийн хүндрэлтэй нөхцөл байдалд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байдлыг хангах, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор улаанбуудайн гурил болон мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон гаалийн албан татвараас чөлөөлөхөөр баталсан хууль зорилгодоо хүрсэн байна.

Хэдийгээр хуулийн хэрэгжилт хангагдаж, гурилын нийлүүлэлт нэмэгдэж, үнэ тогтвортой байгаа боловч дотоодын үр тариа, гурил үйлдвэрлэлийн сүлжээнд сөрөг нөлөө учруулсаар байна.

Мөн гурилын импортын албан татварыг үргэлжлүүлэн чөлөөлөх нь Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилж, Улсын Их Хурлаар баталсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 36 дугаар тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Аян өрнүүлэх тухай” тогтоол (Атрын 4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян) зэрэг дунд хугацааны бодлоготой уялдаагүй бөгөөд эдгээрийн хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнд сөргөөр нөлөөлж, аж ахуйн нэгж, үйлдвэрлэгч, малчид, тариаланчдыг өрийн дарамтад оруулах, хөдөөд ажлын байрыг бууруулах, хот, сууринд шилжин ирэгсдийн тоо, нягтралыг нэмэгдүүлэхэд түлхэц болохоор байна.

Хүнсний тухай хуулиар монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг “стратегийн хүнс” гэж тодорхойлон эдгээр хүнсний дотоодын үйлдвэрлэл, хангамжийг тогтвортой байлгах, улирлын нөөц бүрдүүлэх, гамшгийн нөөц бүрдүүлэх, импортын хамаарлыг бууруулахад чиглэсэн бодлогын болон санхүүжилтийн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Өөрөөр хэлбэл, монгол хүний анхдагч, суурь хүнсний хэрэглээ нь “стратегийн хүнс” бөгөөд эдгээрийг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах чадавхтай байх нь манай улсын хүнсний аюулгүй байдлын баталгаа төдийгүй, Үндэсний аюулгүй байдлын нэгэн чухал илэрхийлэл гэж үзэж болно.

Иймээс хүнс, хөдөө аж ахуйн салбарт үүссэн бодит нөхцөл байдлыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн болно.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг дахин өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд хуулийг дагаж мөрдөх хугацааг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс байхаар тусгасан байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байж, өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганаар “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль”-ийг хэлэлцэн, улаанбуудайн гурил, мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлж, тоо хэмжээний болон хугацааны хязгаарлалтгүй импортлохоор эцэслэн баталсан.

“Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль” хэрэгжсэнээр тухайн цаг үеийн хүндрэлтэй нөхцөл байдалд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байдлыг хангах, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах зорилгодоо хүрсэн, нөгөө талаас улаанбуудайн гурил, мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлсний улмаас хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээнд үүссэн бодит нөхцөл байдлыг үндэслэн энэ хуулийг бүхэлд нь хүчингүй болгох шаардлага үүссэн.

“Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль”-иар улаанбуудайн гурил, мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг эргэн гаалийн албан татвартай болгох харилцааг зохицуулж, хүчин төгөлдөр болгож, мөрдөх хугацааг 2025 оны 07 сарын 01-ний өдрөөс байхаар тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 1999 оны “Импортын барааны гаалийн татварын хувь хэмжээ батлах тухай” 27 дугаар тогтоолоор 10, 12, 23 дугаар бүлгийн гаалийн албан татварын хувь хэмжээг 5 хувь, 11 дүгээр бүлгийн улаанбуудайн дээд болон нэгдүгээр зэргийн гурилын гаалийн албан татварыг 15 хувь байхаар тогтоож, энэ тариф мөрдөгддөг.

Монгол Улс хүнсний гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, нөөцийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, бүх төрлийн будаа, элсэн чихэр, ургамлын тос, мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, тэжээлийн үр, тослог ургамал зэргийг гаалийн албан татвараас түр хугацаагаар чөлөөлөх хуулийн зохицуулалтыг удаа дараа авч хэрэгжүүлж байсан.

Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль” хэрэгжихээс өмнө улаанбуудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлж байгаагүй байна.

“Хүнсний тухай хууль”-иар монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг “стратегийн хүнс” гэж тодорхойлсон бөгөөд тус -хуулийн 5 дугаар зүйлийн 5^{1.1}-д зааснаар “Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн

жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд хүргүүлж, тус Үндэсний зөвлөлөөс Монгол Улсын тухайн жилд экспортлох, импортлох хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоодог.

“Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль”-ийн хэрэгжилтийн явцад Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн №002 тоот зөвлөмжөөр “улаанбуудайн гурилын импортын тоо хэмжээнд хязгаарлалт тогтоохгүй байх”, 2024 оны 08 сарын 30-ны өдрийн №003 тоот зөвлөмжөөр “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Цагааннуур, Боршоо, Арцсуурь боомтоор улаанбуудайн баяжуулсан болон баяжуулаагүй гурилыг, бусад боомтоор улаанбуудайн баяжуулсан гурилыг тус тус импортлох зохицуулалтын арга хэмжээ авч ажиллах”, 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 001 тоот зөвлөмжөөр улаанбуудайн гурилын экспорт, импортод тоо, хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байх, 002 тоот зөвлөмжөөр “Монгол Улсад 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс зөвхөн улаанбуудайн баяжуулсан гурилыг импортлох зохицуулалтын арга хэмжээ авч ажиллах”-аар тус тус шийдвэрлэсэн байна.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хэрэгжилтийн талаар хэд хэдэн уулзалт, хэлэлцүүлэг хийсэн бөгөөд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 2024 оны шинэ ургацын улаанбуудай хураахтай холбогдуулан 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр газар тариалангийн салбарын холбоодын төлөөлөлттэй санал солилцох уулзалт, Дархан-Уул аймагт 2024 оны 08 дугаар сарын 25-ны өдөр газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 30 гаруй аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлттэй уулзалт, хэлэлцүүлэгийг тус тус зохион байгуулсан байна. Хэлэлцүүлгийн үеэр тариаланчид болон үйлдвэрлэгчид улаанбуудайн гурил, малын тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлөх хуулийг хүчингүй болгох санал, шаардлагыг гаргасан.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт үүссэн бодит нөхцөл байдлыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .. дугаар сарын ..-ны өдөр

Улаанбаатар хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ